

ЭРДЭНЭ РЕСУРС ХАР МОРЬ ТАЛБАЙД 42.8 Г/Т АЛТНЫ АГУУЛГАТАЙ 15 МЕТРИЙН ИНТЕРВАЛД 5 МЕТРИЙН ТУРШ 123.5 Г/Т АЛТ ОГТОЛЛОО ХҮДЭРЖСЭН БҮСИЙГ ӨНӨӨГ ХҮРТЭЛ ХАМГИЙН ӨНДӨР АГУУЛГАТАЙ ИНТЕРВАЛААР ТЭЛЭВ

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот
2022.02.08

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX: ERD | MSE: ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь Баян Хөндий алтны төслөөс хойд зүгт 2.4 км-т орших Хар Морь талбайн хайгуулын үр дүнг танилцуулахад таатай байна.

Онцлох мэдээлэл

- Хар Морийн Дэл бүсийн хүдэржилтийг өмнө зүгт 100 метр тэлэв
 - Энэхүү бүс нь хойд, өмнө зүгт болон гүндээ нээлттэй
- Хар Морь бүсэд газрын гадаргаас эхлэн, өнөөг хүртэл хамгийн өндөр алтны агуулга бүхий хүдэржилт огтолсон
 - AAD-176: газрын гадаргаас эхлэн 6.4 г/т алтны дундаж агуулга бүхий 18 метр
 - Үүнд 25.2 г/т алтны агуулга бүхий 4 метр интервал багтаж байна.
 - AAD-177: Цооногийн 1 метрээс эхлэн 11.4 г/т алтны дундаж агуулга бүхий 23 метр
 - Үүнд 32.2 г/т алтны агуулга бүхий 8 метрт 59.8 г/т алтны агуулга бүхий 4 метрийн интервал багтаж байна.
 - AAD-178: Цооногийн 11 метрээс эхлэн 42.8 г/т алтны дундаж агуулга бүхий 15 метр
 - Үүнд 123.5 г/т алтны агуулга бүхий 5 метрт 160.4 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал багтаж байна.
 - Хоёр цооногт 100 г/т алтны агуулгаас дээш (195 г/т алтны агуулга хүртэл) интервал илэрсэн
- Хөндий дүүргийн хэмжээнд газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий исэлдсэн алтны хүдэржилтийн боломжийг тодорхойлов
 - Эрдэнэ Ресурсийн Хөндий, Улаан болон Алтан Нар тусгай зөвшөөрлийн талбайд ижил төстэй шинж чанар бүхий хэд хэдэн талбайг тодорхойлсон

Тодруулга

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Өнөөдрийн энэхүү үр дүнгүүд нь Хар Морь талбай дахь өнөөг хүртэлх хамгийн өндөр агуулга бүхий интервалуудыг агуулсан бөгөөд маш өндөр агуулгатай исэлдсэн алтны бүсийг тэлснээрээ онцлог юм. Энэхүү газрын дөт гүн дэх бүсийн тэлэлт нь Баян Хөндий алтны төслийн богино хугацааны мөнгөн урсгалыг өсгөж, Хөндий Алтны Дүүрэгт трендийн дагуу болон исэлдсэн алтны хэтийн төлөв бүхий талбайн хайгуулыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.”

“Баян Хөндий алтны төсөлтэй залгаа орших энэхүү хүдэржилт бүхий талбайн санхүүгийн болон техникийн нөлөөллийг үнэлэх судалгааны ажлууд хийгдэж байна. Компани нь олон сая унц бүхий алтны дүүргийг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2022 оны хайгуулын өрөмдлөгийн хөтөлбөрийг боловсруулж, 1-р улирлын сүүлээр нарийвчилсан өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэнэ.”

Өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнгүүд

Хар Морь талбайн өрөмдлөгийн хөтөлбөрийг 2021 оны 12 сард эцэслэсэн. Энэхүү өрөмдлөгөөр Хар Морийн Дэл бүсийн структурын дагуу өрөмдсөн өмнөх цооногуудаас өмнөд, хойд зүгт (суналын дагуу) газрын дөт гүнд исэлдсэн алтны хүдэржилт үргэлжилж байгаа эсэхийг шалгах зорилготой. Энэхүү хөтөлбөрөөр 1,586 тууш метрийн 23 цооног, 1 сунгалтын цооног өрөмдсөн. Цооногуудын дундаж гүн 66 метр, бодит гүн нь дунджаар 47 метр байсан.

Өрөмдлөгийн хөтөлбөрөөр Хар Морийн Дэл талбайд газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий алтны хүдэржилт өмнө зүгт 100 метр үргэлжилж байгааг тогтоон, өмнө зүгт 700 метр зайд том торлолоор өрөмдсөн хэсэгт хүчтэй гидротермаль хувиралд алт, антимон, хүнцлийн хэсэгчилсэн аномаль байгааг мөн илрүүлсэн. Өрөмдлөгийн үр дүнд хоёр цооногт 100 г/т алтны агуулгаас дээш (195 г/т алтны агуулга хүртэл) хэд хэдэн 1 метрийн интервалыг огтолсон нь өнөөг хүртэл мэдэгдэж буй хамгийн өндөр алтны агуулга боллоо. Өмнө зүгт дөт гүн дэх алтны исэлдсэн хүдэржилтийн суналын урт ойролцоогоор 600 метр байгааг тодорхойлсон.

Хар Морийн Дэл бүсийн хойд хэсэгт гүйцэтгэсэн өрөмдлөгөөр өргөн хэмжээний шаврын хувирал болон бага агуулга бүхий алтны хүдэржилтийг (AAD-186 цооногт 0.64 г/т алтны агуулга бүхий 15 метр) огтолсноор бүсийг өмнө зүгт тэллээ. Хар Морийн Дэл бүсийн хойд хэсэг дэх алт агуулагч исэлдсэн бүсийн хойд төгсгөлд нарийн бүсүүдийг огтлон, суналын урт 500 метр байгааг тодорхойлсон.

Өрөмдлөгийн хөтөлбөрийн онцлох мэдээллийг Хүснэгт 1-т харуулсан бөгөөд өрмийн цооногуудын план зураглал болон хөндлөн зүсэлттэй хавсралт зургуудаас танилцана уу.

Хүснэгт 1: Хар Морь 2021 оны 4-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрийн онцлох мэдээлэл

(Дунджаар 0.30 г/т алтны агуулгаас дээш интервалуудыг танилцуулав)

Цооног	м-ээс	м хүртэл	Интервал ⁽¹⁾	г/т алт
AAD-173	42	44	2	1.57
AAD-174	2	18	16	0.78
AAD-175	0.5	12	11.5	1.54
түүнд	7	10	3	4.82
түүнд	8	9	1	10.16
AAD-176	0	18	18	6.4
түүнд	3	7	4 ⁽²⁾	25.18
AAD-177	1	24	23	11.37
түүнд	6	14	8	32.32
түүнд	9	13	4 ⁽³⁾	59.84
түүнд	10	11	1	121.09
AAD-178	11	26	15	42.84
түүнд	13	18	5 ⁽⁴⁾	123.47
түүнд	14	17	3 ⁽⁵⁾	160.41
AAD-179	29	38	9	0.53
ба	48	51	3	1.15
ба	55	58	3	1.11
AAD-183	0.4	5	4.6	0.82
ба	10	14	4	0.32
AAD-184	6	7	1	0.93
ба	10	15	5	0.33
AAD-185	0.5	6	5.5	0.87
AAD-186	33	48	15	0.64
AAD-188	44	45	1	0.38
ба	59	62	3	0.38
AAD-190	16	20	4	0.38

1. Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропыг тодорхойлох боломжтой.
2. 10 г/т-с дээш алтны агуулга бүхий 1 метрийн 4 ширхэг дээж агуулсан; 13.14 - 59.66 г/т хооронд алтны агуулга бүхий
3. 10 г/т-с дээш алтны агуулга бүхий 1 метрийн 4 ширхэг дээж агуулсан; 12.98 - 121.09 г/т хооронд алтны агуулга бүхий
4. 10 г/т-с дээш алтны агуулга бүхий 1 метрийн 5 ширхэг дээж агуулсан; 39.44 - 194.61 г/т хооронд алтны агуулга бүхий
5. 100 г/т-с дээш алтны агуулга бүхий 1 метрийн 3 ширхэг дээж агуулсан; 118.03 - 194.61 г/т хооронд алтны агуулга бүхий

Хар Морь талбайн тухай

Өнөөг хүртэл гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр Хар Морийн Дэл бүсэд трендийн хувирал болон алтны хүдэржилт бүхий 1.5 км талбайг тодорхойлсон нь суналын дагуу, өмнө, хойд зүгт, мөн гүндээ нээлттэй байна.

Эрдэнэ Ресурс нь 2021 оны эхээр Баян Хөндий ордоос хойд зүгт 2.4 км-т өрөмдлөгийн хөтөлбөр гүйцэтгэснээр Хар Морийн Дэл бүсийг илрүүлсэн. Энэхүү

өрөмдлөгөөр (AAD-58) цооногийн 10 метрээс 27.1 г/т алтны агуулга бүхий 8 метр агуулсан 5.97 г/т алтны агуулга бүхий 45 метрийн интервал огтолсон. Энэхүү нээлт нь 1 г/т алтны агуулгаас өндөр чөмгөн дээж, суваг малталт болон гадаргын чулуулгийн дээжлэлт бүхий хөрсний аномализм дахь алтны утгаар тодорхойлогддог Хар Морь талбайд (38 км²) оршдог.

Компани нь Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд орших Хар Морь талбайд нийт 21,673 тууш метрийн 190 цооногийг босоо тэнхлэгийн дагуу 21-ээс 318 метрийн гүнд өрөмдсөн.

Хар Морийн Дэл бүс нь анхдагч эрдэсжүүлэгч шингэнийг дамжуулагч хэмээн тайлбарладаг зүүн хойд трендийн дагуу гүнд байрлах хувирлын хагарлыг огтолж буй хойд өмнөд тренд, шугаман структурын коридортой холбогддог. Хойд-Өмнөд структур нь Баян Хөндийн өмнөд хэсгээс Хар Морийн хойд тэлэлтийн бүс хүртэл 5 км талбайг хамардаг. Алтны хүдэржилт нь кварц, кварц-гематит судал болон штокверк бүсээр огтолсон хүчтэй хувирсан туф болон галт уулын чулуулгийн дотор оршиж байна. Хар Морийн Дэлийн дөт гүн дэх исэлдсэн бүс нь газрын гадаргаас эхлэн, 1 метрээс дээш 195 г/т алтны агуулга бүхий супергенээр баяжуулсан алтны бүсүүдийг агуулан, хугарлын дагуу хэсэгчлэн гүн исэлдэн 20-60 метрийн босоо гүнд өөр өөр зузаантай оршиж байна. Өндөр агуулга бүхий исэлдсэн биет нь хойд өмнөд суналын дагуу үргэлжилж байгааг тодорхойлсон. Хүдэржилт нь суналын дагуу болон гүндээ нээлттэй. Алт агуулсан исэлдсэн бүсүүд нь Хөндий-Улаан хувирлын ул мөр дэх элэгдэлтийн түвшин, гидрогеологи болон агаар мандлын нөхцөл зэрэг гүн исэлдэлт болон алтны хүдэржилтийг супергенээр баяжуулах таатай нөхцөл бүрдүүлснийг илэрхийлдэг. Энэ нь Хөндий дүүрэгт газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий алтны хүдэржилтийн нэмэлт нээлт хийх боломжтойг харууллаа.

Хар Морийн Дэл бүс дэх газрын дөт гүний исэлдсэн алтны бүс нь цагаан гялтгануураар хувирсан литологи агуулагч гидротермаль брекч ба сульфид агуулсан эпитеpmаль судлын исэлдлийн үр дүн юм. Өрөмдлөгийн хязгаарлагдмал гүний судалгаагаар алт агуулагч эпитеpmаль судал түүнтэй холбоотой цагаан гялтгануур сульфид хувирлын бүсүүд нь босоо гүнд 230 метр хүртэл ажиглагдсан бөгөөд гүндээ нээлттэй. Хар Морийн Дэл бүсийн газрын дөт гүн дэх алтны хүдэржилт нь структурын хяналттай хувирал болон өргөн бүсийг хамран палеон гадарга руу ойртон алт агуулагч шингэнийг тараан, тэжээгч структуртай холбогдож байна хэмээн үздэг. Эдгээр тэжээгч структур нь гүндээ зэсийн аномаль нэмэгдэж буй алтны хүдэржилтээс өмнөх үетэй холбогдон, хэд хэдэн ил гарсан үлдэгдэл кварцын литокапуудыг агуулдаг. Эдгээр литокапууд нь гүндээ магмын порфирын эх үүсвэрээс тэжээгч бүсүүд болон хагарлын хувирлыг төлөөлж буй Хойд-Өмнөд трендийн структурын дагуу давамгайлсан тархсан. Дээр танилцуулсан өндөр агуулга бүхий алт агуулагч исэлдсэн бүсүүд нь кварц литокапийн үлдэгдэл болон туфаас порфирт галт уулын задралын нэгжид байрлаж байна.

Ирээдүйн төлөвлөгөө

Эрдэнэ Ресурсийн 2,309 га бүхий Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хойд хэсэгт Хар Морь талбайд судлагдаагүй хэрнээ хэтийн төлөвтэй хэд хэдэн бүс

тодорхойлогдсон. Түүнээс гадна, Хар Морийн Дэл бүсэд өнөөдрийг хүртэл хийсэн өрөмдлөгүүд нь харьцангуй гүехэн байсан тул Хар Морийн Дэлийн алтны хүдэржилт нь судлын дагуу болон гүндээ нээлттэй хэвээр байна. Компани нь Хар Морь ерөнхий талбайд өгөгдөл цуглуулах, тайлал болон цооног тодорхойлох ажлуудыг гүйцэтгэж байна. Энэхүү ажлууд нь алтны аномальд төвлөрөн, тэжээгч бүсүүд болон Хар Морийн Дэл бүстэй төстэй дөт гүний исэлдсэн алтны хүдэржилтийг тодорхойлох, алтны хүдэржилтийн гүн бүсүүдийг тогтооход чиглэнэ. Компанийн өнөөгийн геологийн загвараар Хар Морь талбайд хийсэн өрөмдлөгүүд нь алтны эпитермаль ордод илэрдэг өндөр агуулга бүхий буцлах бүсээс дээш оршиж байна хэмээн тодорхойлдог.

Хөндий алтны дүүрэг

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлсэн. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

Баян Хөндийд 2.19 г/т дундаж алтны агуулга бүхий 585,100 унц баттай болон бодитой геологийн нөөц¹ (“Measured and Indicated Resources”)², 2.18 г/т алтны агуулга бүхий 35,900 унц боломжит нөөц (“Inferred Resources”)³ тодорхойлогдсон. Баттай болон Бодитой нөөцөд 3.7 г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтдаг. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Баттай болон бодитой нөөц, боломжит нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой.

2020 оны 7-р сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Нарийвчилсан ТЭЗҮ-ийн суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (NPV5%) \$100 сая ам.доллар ба дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон. Баян Хөндийн нарийвчилсан ТЭЗҮ нь 0-7 жилийн хугацаанд 3.71 г/т алтны дундаж агуулга бүхий, жилд 63,500 унц алт олборлохоор тооцоолсон бөгөөд уламжлалт нүүрстэй уусгах технологиор боловсруулахаар төлөвлөсөн. Төслийн төлөвлөгөөгөөр олборлолтыг 2023 онд эхлүүлнэ.

¹ Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2021 оны 8 сарын 16-нд танилцуулсан 2021 оны 2-р улирлын санхүү болон үйл ажиллагааны тайлангийн хэвлэлийн мэдээнээс танилцана уу.

² Баттай & Бодитой геологийн нөөц: 2.39 г/т алтны агуулга бүхий 232,700 унц баттай, 2.08 г/т алтны агуулга бүхий 352,400 унц бодитой нөөц

³ Батлагдсан & Магадласан: 4.4 г/т алтны агуулга бүхий 165,000 унц батлагдсан, 3.4 г/т алтны агуулга бүхий 256,000 унц магадласан үйлдвэрлэлийн нөөц; Үйлдвэрлэлийн нөөцийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хөндий Алтны Төсөл NI 43-101 Техникийн Тайлан, Tetra Tech 2019 оны 12 сарын 4-нд SEDAR болон компанийн вебсайт дээрх мэдээлэлтэй танилцана уу.

Эрдэнэ Ресурсийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуулын 2, ашиглалтын 3 тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс ("SGS") лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт ("QA/QC")-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмит спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screen-metallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 гр дээжний 75 микроноос бага байх 30 гр бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцагт үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн Улаанбаатар дахь Эс Жи Эс ("SGS") лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнэ Ресурсийн ложистикийн гэрээт Монруд ХХК гүйцэтгэдэг.

Тайлагнасан интервал нь бодит зузаан бөгөөд өөрөөр хэлбэл цооногийн өргөн юм. Улаан талбайн өрөмдлөгийн цооногуудыг 85 градусын уналаар өрөмдсөн ба алт агуулсан судлын баруун-хойд баруун трендийн дагуу баруун урд уналын дагуу чиглэсэн. Бодит өргөнийг баталгаажуулахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Интервалуудын тайлагнасан агуулга нь түүвэр интервалын уртад үндэслэсэн жигнэсэн дундаж үзүүлэлтүүд юм. Дээд хязгаарлалт хийгээгүй боловч 10 г/т алтны агуулгаас өндөр агуулга бүхий интервалыг тодруулахаар тусад нь тайлагнадаг.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: info@erdene.com

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>


DARK HORSE DRILLING CONFIRMS OXIDE GOLD AT SURFACE

Khundii – Ulaan Licenses, Bayan Khundii Deposit and Prospect Location Map

Khundii – Ulaan Active Discoveries and Prospects




Khundii – Ulaan Hydrothermal Alteration Footprint



GREATER DARK HORSE PROSPECTS MAP

High Potential for Further Discoveries




KHUNDII LONG SECTION – 3D Magnetics

0.1 g/t Gold Grade Shell

Bayan Khundii Gold Deposit

Dark Horse Mane Gold Project




DARK HORSE MANE (SOUTH) – SECTION A (Looking West)

AAD-174 4m of 1.6 g/t Incl. 1m of 2.6 g/t	AAD-175 3m of 4.8 g/t Incl. 1m of 10.2 g/t	AAD-176 18m of 6.4 g/t Incl. 4m of 25.2 g/t	AAD-177 23m of 11.4 g/t Incl. 4m of 59.8 g/t	AAD-178 15m of 42.8 g/t Incl. 5m of 123.5 g/t
--	---	--	---	--

Interpolated Gold Grade Shells

- New Collar
- Previous Collar
- ≥ 2.0 g/t
- ≥ 0.3 g/t
- ≥ 0.1 g/t



DARK HORSE MANE PLAN MAP

